



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 8/нэ

Улаанбаатар хот

Хөлбөмбөгийн ахмадын тэмцээнийг зохион байгуулах тухай

Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хууль, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг даргын 2013 – 2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2015 оны зорилтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын аварга шалгаруулах ахмадын хөлбөмбөгийн тэмцээнийг 2015 оны 09 дүгээр сарын 23-27-ны өдрүүдэд Монголын хөлбөмбөгийн холбоо, Улаанбаатар хотын хөлбөмбөгийн холбоо, Монголын спорт сонирхогч мастеруудын холбоо, “Их талын дуулиан ТББ”-тай хамтран Улаанбаатар хотноо зохион байгуулсугай.

2. Тэмцээнийг хамтран зохион байгуулахад шаардагдах төсвийг баталсугай.

3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 1.000.000 /нэг сая/ төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын төвлөрсөн төсвийн уралдаан тэмцээний зардлаас гаргахыг ня-бо О.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.

4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг мэргэжилтэн Б.Батсайханд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2015 оны сарын-ны өдрийн
..... дугаар тушаалын хавсралт

Ахмадын хөлбөмбөгийн тэмцээнийг
зохион байгуулах төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Медалийн үнэ: 35-39 нас 40 х 5.000 төг = 200.000 төг 40-44 нас 40 х 5.000 төг = 200.000 төг 45-49 нас 40 х 5.000 төг = 200.000 төг 50-54 нас 40 х 5.000 төг = 200.000 төг 55-59 нас 40 х 5.000 төг = 200.000 төг	1.000.000
ДҮН:		1.000.000

Боловсруулсан: Мэргэжилтэн

Б.Батсайхан

Хянасан: Нягтлан бодогч

О.Эрдэнэцэцэг